



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас:70007734, Факс: (976-11) 32 01 54,  
E-mail: ub@audit.gov.mn; http://www.city.audit.mn

2019.02.25 № 832

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН  
ГАЗРЫН ДАРГА, ТӨСВИЙН ШУУД  
ЗАХИРАГЧ Ж.ДАМДИНЦЭРЭН  
ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Соёл, урлагийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Нийслэлийн соёл, урлагийн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийслэлийн Соёл, урлагийн газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын

хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### **Аудитын гол асуудал**

2018 оны жилийн эцсийн хөрөнгийн тооллогод 24,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 850.0 мянган төгрөгийн шатах тослох материал биетээр байхгүй, бараа материалын дансанд бүртгэлтэй 401,692.0 мянган төгрөгийн хөрөнгийг тооллого хийж баталгаажуулаагүй, санхүүгийн дотоод хяналт хангалтгүй байсан зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, оршин байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



С.ЭНХБААТАР